




Монгол Улс Төв Ази дахь хөрш улсуудтайгаа хэрхэн харьцуулагдаж байна вэ?



81-100 Иж бүрэн

61-80 Боломжийн

41-60 Зарим


21-40 Бага зэргийн

0-20 Хангалтгүй буюу огт байхгүй


Төсвийн найман гол баримт бичиг юу болох, тэдгээр нь олон нийтэд хүртээмжтэй байна үү?

Баримт бичиг	Баримт бичгийн тодорхойлолт	Хэвлэгдсэн байдал
ТУМ	Төсвийн урьдчилсан мэдэгдэл /буюу төсвийн хүрээний мэдэгдэл/: Төсвийг Засгийн газрын бодлоготой уялдуулсан мэдээллээр хангах ба ерөнхийдөө хууль тогтоох байгууллагад өргөн мэдүүлэх төсвийн саналыг тодорхойлох өргөн цар хүрээтэй параметрууд тусгагдана.	Нийтлэгдсэн
БТ	Батлагдсан төсөв: Гүйцэтгэх засаглалд орлого олох, зарлага гаргах, зээл авах эрх олгосон хуулийн хэрэгсэл.	Нийтлэгдсэн
ГЗТС	Гүйцэтгэх засаглалын төсвийн санал \буюу төсвийн төсөл\: Татвар болон бусад эх үүсвэрээс орлого олох ба эдгээр орлогыг Засгийн газрын тэргүүлэх зорилтыг санхүүжүүлэхэд зарцуулах буюу бодлогын зорилтыг үйл ажиллагаа болгох Засгийн газрын төлөвлөгөө.	Нийтлэгдсэн
ИТ	Иргэдэд зориулсан төсөв: Бодлогын зорилтод хүрэхийн тулд орлого олох, нийтийн хөрөнгийг зарцуулах Засгийн газрын төлөвлөгөөг олон нийтэд ойлгомжтой болгож харуулсан техникийн бус тайлан.	Боловсруулаагүй
ЖЯТ	Жилийн явцын тайлангууд: Төсвийн тоо, өөрчлөлтийг харьцуулан харах боломж олгох төсвийн бодит орлого, зарлага, өрийн чиг хандлагын тогтмол /сарын эсвэл улирлын/ мэдээлэл.	Нийтлэгдсэн
ХЖТ	Хагас жилийн тойм: Төсвийн жилийн дунд цэгт хийх төсвийн үр нөлөөний талаархи тойм ба батлагдсан төсвийн бодлогод нөлөөлж байгаа эдийн засгийн таамаглалд орсон аливаа өөрчлөлтийг харуулдаг.	Дотоод хэрэгцээнд зориулж боловсруулсан
ЖЭТ	Жилийн эцсийн тайлан: Төсвийн бодит гүйцэтгэлийг батлагдсан төсөвтэй харьцуулсан мэдээлэл.	Нийтлэгдсэн
АТ	Аудитын тайлан: Тухайн улс орны аудитын дээд байгууллагаас Засгийн газрын тайланг хараат бусаар үнэлсэн үнэлгээ. Энэ нь ерөнхийдөө гүйцэтгэх засаглал батлагдсан төсвийн дагуу орлого олж, зарлага гаргасан эсэх, Засгийн газрын орлого зарлагын тайлангууд нь үнэн зөв, төсвийн байдлыг бодитой харуулсан эсэхийг үнэлдэг.	Нийтлэгдсэн

0-100 хүртэл. Монгол Улс төсвийн найман гол баримт бичигт орсон мэдээллийн хэмжээг нэмэгдүүлсэн үү?



НЭЭЛТТЭЙ ТӨСВИЙН ИНДЕКСИЙН ОНОО



НЭЭЛТЭЙ ТӨСВИЙН ИНДЕКС (НТИ)

Нээлттэй төсвийн судалгаа нь төсвийн найман гол баримт бичгийг төв засгийн газрууд олон нийтэд ил тайлагнасан байдал, мөн эдгээр баримт бичигт орсон мэдээллийн иж бүрэн, шуурхай ашиглаж болохуйц байдалд үнэлгээ өгдөг. Уг судалгаанд Олон Улсын Валютын Сан, Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллага, Олон Улсын Аудитын Дээд Байгууллага зэрэг олон улсын байгууллагуудын боловсруулсан, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шалгуур

Монгол Улс 100 онооноос 51 оноо авсан нь судалгаанд хамрагдсан 100 улс орны дундаж үзүүлэлт болох 43 онооноос өндөр байгаа боловч өөрийн бүс нутгийн Гүрж, Орос, Украин зэрэг улсынхаас доогуур оноотой байна. Засгийн газар нь тухайн жилийн улсын төсөв, санхүүгийн үйл ажиллагааны талаар зарим мэдээллийг л олон нийтэд өгдөг болохыг Монгол Улсын оноо харуулж байна. Энэ нь нийтийн мөнгийг Засгийн газар хэрхэн удирдаж байгаад иргэд хяналт тавихад хүндрэл учруулахаар байна.

Монгол Улс 2010 онд НТИ-ээрээ 60 оноо авсан бол 2012 онд 51 оноотой болж ухарчээ.

Нээлттэй төсвийн индексийг судалгаанд хамрагдсан төсвийн найман гол баримт бичиг тус бүрд оноо өгөх байдлаар гаргасан болно. Эдгээр дэд оноо нь тухайн баримт бичгүүдэд байгаа мэдээллийн хэмжээ, олон нийт олж авч чадах байдлыг хэмжих судалгааны багц асуултуудад хариулсан байдлаас гаргасан дундаж оноо юм. Дэд оноог судалгаанд хамрагдсан бүх улс орны авсан дэд оноотой харьцуулах боломжтой.

Зөвлөмж

Монгол Улс 2010 онд НТИ-ээрээ 60 оноо авсан бол 2012 онд 51 оноотой болж ухарчээ. Энэ нөхцөлд Монгол Улсын Засгийн газар тэр бүр зардал шаардахгүй богино, дунд хугацааны цөөнгүй арга хэмжээ авч хэрэгжүүлэх замаар төсвийн ил тод байдлыг ихээхэн нэмэгдүүлэх боломж байна.

Монгол Улс төсвийн ил тод байдлыг дээшлүүлэх талаар доорхи алхмуудыг авч хэрэгжүүлэхийг Олон Улсын Төсвийн Түншлэл (ОУТТ)-ээс зөвлөж байна. Үүнд:

■ Ирэх оны төсвийн дэлгэрэнгүй тооцооллыг боловсруулах ажлын удирдамж болох Засгийн газрын бодлого, тэргүүлэх чиглэлийг тайлбарлах замаар Төсвийн өмнөх мэдэгдлийн иж бүрэн байдлыг нэмэгдүүлэх (Нээлттэй төсвийн санал асуулгын асуулт 62-ийг үзнэ үү).

■ Хагас жилийн тоймыг нийтлэх. Одоогоор Монгол Улс хагас жилийн тоймыг дотоод хэрэгцээнд зориулж боловсруулж байна (Энэ баримт бичгийн агуулгын дэлгэрэнгүй зааврыг <http://bit.ly/QGzHv8>-аас үзэж болно). Нээлттэй төсвийн судалгаа-2012-ын

үзүүлэлтээр улс орон бүрийн төсвийн ил тод байдлыг үнэлдэг.

Нээлттэй төсвийн судалгааг бүрдүүлэгч 125 асуултын 95-д нь авсан оноог ашиглаж судалгаанд хамрагдаж байгаа улс орон тус бүрийн харьцангуй ил тод байдлыг бодитой оноо өгөх, эрэмбэлэх замаар тооцдог. Эдгээр нийлбэр оноо нь төсвийн ил тод байдлын талаархи дэлхийн цорын ганц хараат бус, харьцуулсан хэмжигдэхүүн болох Нээлттэй төсвийн индексийг бүрдүүлдэг.

хувьд Азербайжан зэрэг 29 орон хагас жилийн тоймыг нийтэлж байна. Эдгээр улс орнуудын нийтэлсэн төсвийн баримт бичгийг Олон Улсын Төсвийн Түншлэл байгууллагын вэб сайт <http://bit.ly/P8NPOV/>-аас авах боломжтой.

■ Иргэдэд зориулсан төсвийн баримт бичгийн агуулгын талаарх дэлгэрэнгүй зааврыг <http://bit.ly/QGzFmJ>-аас авах боломжтой. Нээлттэй төсвийн судалгаа-2012-ын хувьд Төв Азийн бүс нутгийн хөрш Казакстаныг оролцуулаад 26 улс орон Иргэдэд зориулсан төсвийг нийтэлдэг байна. Эдгээр улс орны нийтэлсэн төсвийн баримт бичгийг Олон Улсын Төсвийн Түншлэлийн вэб сайт <http://bit.ly/P8NPOV/>-аас авах боломжтой.

■ Ялангуяа дараах чиглэлийн мэдээллийг өгөхөд анхаарах замаар Гүйцэтгэх засаглалын төсвийн саналын иж бүрэн байдлыг нэмэгдүүлэх хэрэгтэй. Үүнд:

- Төсвийн жилийн зарлагын чиг үүргийн ангилал, олон жилийн зардлын нийт дүнгийн тооцоо (Нээлттэй төсвийн судалгааны асуулгын Асуулт 2, 5, 6-г үзнэ үү);
- Төсвийн жилийн өмнөх жилийн зарлагын чиг үүргийн ангилал ба зарлагын гүйцэтгэл (Нээлттэй төсвийн судалгааны асуулгын Асуулт 19, 22-г үзнэ үү);
- Төсвийн жилээс гадна хамгийн багадаа дараагийн хоёр жилийн болон төсвийн өмнөх жилийн орлогын таамаглал (Нээлттэй төсвийн судалгааны асуулгын Асуулт 9,10-г үзнэ үү);
- Төсвийн жилийн Засгийн газрын нийт өрийн үлдэгдэл хийгээд Засгийн газрын өрийн бүтэц (Нээлттэй төсвийн судалгааны асуулгын Асуулт 11, 13-г үзнэ үү);
- Төсвийн жилийн өмнөх жилийн Засгийн газрын өр төлбөр болон өр төлбөрийн бодит гүйцэтгэл (Нээлттэй төсвийн судалгааны асуулгын Асуулт 33,34-г үзнэ үү);
- Макро-эдийн засгийн төрөл бүрийн таамаглалын төсөвт үзүүлэх нөлөө (тухайлбал, мэдрэмжийн шинжилгээ хийх замаар тодорхойлсон нөлөө) (Нээлттэй төсвийн судалгааны асуулгын Асуулт 15-г үзнэ үү);
- Зарлагад нөлөөлж байгаа хүчин төгөлдөр бодлогуудаас зөрүүтэй бодлогын санал, Засгийн газрын тодорхойлсон олон жилийн бодлогын зорилттой санал болгож буй төсвийн уялдсан байдал, санхүүгийн бус мэдээлэл, зарлагын хөтөлбөрийн гүйцэтгэлийн үзүүлэлтүүд, наад зах нь төсвийн жилийн хувьд улс орны хүн амын хамгийн ядуу хэсэгт шууд үр ашиг нь хүрэхээр төлөвлөсөн бодлогын талаарх мэдээлэл (Нээлттэй төсвийн судалгааны асуулгын Асуулт 15, 49-55-ыг үзнэ үү);

- Төрийн өмчит газруудын шилжүүлгүүд, хагас санхүүгийн үйл ажиллагаа, зарлагын хойшлуулалт /өр/, нөхцөлт ба ирээдүйн өр төлбөр, санхүүгийн болон санхүүгийн бус хөрөнгө, татварын зарлага (Нээлттэй төсвийн судалгааны асуулгын Асуулт 37-43, 45-ыг үзнэ үү) .

- Сар бүрийн өр төлбөрийн бүтэц (хүүгийн хувь хэмжээ, валютын төрөл, гадаад болон дотоод г.м.)-ийн тухай мэдээллийг оруулах замаар Жилийн явцын тайлангийн иж бүрэн байдлыг нэмэгдүүлэх, (Нээлттэй төсвийн судалгааны асуулгын Асуулт 71-ыг үзнэ үү).

- Макро-эдийн засгийн хувьсах хэмжигдэхүүнүүд, санхүүгийн бус үзүүлэлтүүд, гүйцэтгэлийн үзүүлэлт, ядуу хэсэгт чиглэсэн зорилтот хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх хөрөнгө сан, төсвөөс гадуурх сангуудын тооцоо таамаглал, бодит гүйцэтгэлийн хоорондын ялгааны талаархи дэлгэрэнгүй тайлбарыг оруулах замаар Жилийн эцсийн тайлангийн иж бүрэн байдлыг нэмэгдүүлэх, (Нээлттэй төсвийн судалгааны асуулгын Асуулт 82-86-г үзнэ үү).

- Тайланд хураангуй хэсгийг нэмж оруулах, төсвийн гадуурх сангуудын талаархи аудитын тайланг нийтлэх, аудитын зөвлөмжийн дагуу гүйцэтгэх засаглалаас авсан арга хэмжээний жагсаалт бүхий тайланг нийтлэх замаар Аудитын тайлангийн иж бүрэн байдлыг нэмэгдүүлэх, (Нээлттэй төсвийн судалгааны асуулгын асуулт 89,91,91,108-ыг үзнэ үү).

Хууль тогтоох хийгээд Аудитын дээд байгууллагуудын төсөвт хяналт тавих чадавхи

Нээлттэй төсвийн судалгаа нь хууль тогтоох хийгээд аудитын дээд байгууллагуудын үр дүнтэй хяналт тавьж байгаа байдлыг судалсан. Эдгээр байгууллагууд нь улсын төсвийг төлөвлөх, хэрэгжилтэд хяналт тавихад чухал үүрэг гүйцэтгэдэг ба олон улсад уг үүргийг үндсэн хуулиар баталгаажуулж өгдөг.

Монгол Улс төсвийн хяналтын үзүүлэлтээр Төв Азид өндөр үзүүлэлттэй хэдий ч оролцооны үзүүлэлт сул байна.

Улс	Хууль тогтоох байгууллагын чадавхи	Аудитын дээд байгууллагын чадавхи	Олон нийтийн оролцоо
Азербайжан	Дунд зэрэг	Сул	Сул
Гүрж	Хүчтэй	Хүчтэй	Дунд зэрэг
Казакстан	Хүчтэй	Сул	Сул
Киргизстан	Дунд зэрэг	Дунд зэрэг	Сул
Монгол	Хүчтэй	Хүчтэй	Сул
Орос	Хүчтэй	Хүчтэй	Сул
Тажикстан	Хүчтэй	Хүчтэй	Сул
Украйн	Дунд зэрэг	Хүчтэй	Сул

Хүчтэй: дундаж оноо 66-аас дээш, Дунд зэрэг: 34-66, Сул: дундаж оноо 34-өөс доош

Нээлттэй төсвийн судалгаа нь хууль тогтоох байгууллагууд төсвийг үр дүнтэй хянаж байгаа эсэхийг 11 үзүүлэлтийн гүйцэтгэлээр хэмжиж үнэлсэн. Үүнд төсвийн төслийг хууль тогтоох байгууллагад өргөн мэдүүлэхээс өмнө гүйцэтгэх засаглалтай хэлэлцсэн байдал, судалгааны чадавхи, төсвийн нэгдсэн бодлогын талаархи албан ёсны мэтгэлцээн, төсвийг хэлэлцэж, батлахад зориулагдсан цаг хугацаа, төсвийн саналд өөрчлөлт оруулах хуулийн бүрэн эрх, зарлагын төсөв, хэтэрсэн орлогыг шилжүүлэн ашиглахыг батлах, төсвийн тодотголтой холбоотой эрх мэдэл, нөөц буюу нөхцөлтэйгээр зарцуулах сангийн ашиглалтыг батлах бүрэн эрх, аудитын тайланг хянах зэрэг үзүүлэлтүүд орно.

Нээлттэй төсвийн судалгаа нь аудитын дээд байгууллагад төсөвт үр дүнтэй хяналт тавих бүрэн эрх олгогдсон эсэхийг дараах дөрвөн үзүүлэлтийг ашиглан үнэлсэн. Үүнд: Аудитын дээд байгууллагын удирдлагыг өөрчлөх эрх мэдэл, төрийн санхүүд аудит хийх хуулиар олгогдсон эрх мэдэл, санхүүгийн хангалттай нөөц, аудит хийх боловсон хүчний үр чадвар зэрэг багтана.

Зөвлөмж

Монгол Улс төсвийн хяналтыг сайжруулах талаар дараах арга хэмжээ авахыг Олон Улсын Төсвийн Түншлэлээс зөвлөж байна. Үүнд:

- Гүйцэтгэх засаглал төсвийн зориулалтыг өөрчлөхөд хууль тогтоох байгууллагын саналыг авах, төлөвлөснөөс илүү орлого, нөхцөлт буюу нөөц сангийн хөрөнгийг зарцуулахдаа хууль тогтоох байгууллагаар батлуулах; хууль тогтоох байгууллагын аль нэг хороо аудитын тайланг хянан үзэх. (Нээлттэй төсвийн судалгааны асуулгын Асуулт 103,104,106,107-г үзнэ үү).

- Аудитын дээд байгууллагын төсвийг хууль тогтоох байгууллагаас тогтоох ба санхүүжилтийн хэмжээ нь аудитын дээд байгууллага өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах эх үүсвэрийн хэмжээтэй бүхэлдээ уялдах ёстой. (Нээлттэй төсвийн судалгааны асуулгын Асуулт 93-ыг үзнэ үү).

Олон нийтийн оролцох боломж

Засаглалыг сайжруулахад дан ганц ил тод байдал хангалтгүй гэдгийг сүүлийн 15 жилийн иргэний нийгмийн судалгаа, нөлөөллийн ажлын туршлага харуулж байна. Нээлттэй төсөвтэй холбоотойгоор гарах эерэг үр дүнг нэмэгдүүлэхийн тулд төсвийн ил тод байдлыг олон нийтийн оролцооны боломжтой хослуулах хэрэгтэй. Тиймээс улсын төсвийн шийдвэр гаргах үйл явцад олон нийтийг оролцуулах боломжийг Нээлттэй төсвийн судалгаа үнэлсэн юм. Ийм боломжийг гүйцэтгэх засаглал, хууль тогтоох байгууллага, аудитын дээд байгууллагын төсвийн мөчлөгийн үе шат тус бүрт олгож болно.

Эдгээр үзүүлэлтэд үндэслэн Монгол Улсад төсвийн үйл явцад олон нийт оролцох боломж хязгаарлагдмал байгааг Нээлттэй төсвийн судалгаа-2012 гаргаж ирсэн.

Шаардлага	Үр дүн
Хэлэлцүүлгийн өмнөх үйл явц	
Олон нийтийн оролцооны албан ёсны шаардлага (Асуулт 114)	Байгаа ч сул
Олон нийтийн оролцооны зорилгыг илэрхийлэх (Асуулт 115)	Байхгүй
Аудитын тайланг нийтлэхээс бусад хэлбэрээр Аудитын дээд байгууллагаас хийх олон нийтийн харилцаа (Асуулт 124)	Хүчтэй байгаа
Хэлэлцүүлгийн үйл явц	
Төсвийн төлөвлөлтийн үе шатанд оролцоог хангахад зориулж гүйцэтгэх засаглалын боловсруулсан механизм (Асуулт 116)	Байгаа ч сул
Макро-эдийн засгийн төсвийн хүрээний талаарх хууль тогтоогч байгууллагад хийх сонгол (Асуулт 119)	Байхгүй
Тодорхой төсвийн байгууллагуудын төсвийн талаарх хууль тогтоогч байгууллагад хийх сонгол (Асуулт 120)	Байхгүй
Хууль тогтоогч байгууллагад төсвийн нээлттэй сонголын үеэр олон нийт мэдэгдэл хийх боломж (Асуулт 121)	Байхгүй
Төсвийн гүйцэтгэлийн үе шатанд оролцоог хангахад зориулж гүйцэтгэх засаглалын боловсруулсан механизм (Асуулт 117)	Байгаа ч сул
Аудитын асуудлаархи оролцоонд зориулж Аудитын дээд байгууллагаас боловсруулсан механизм (Асуулт 123)	Байгаа ч сул
Хэлэлцүүлгийн дараах үйл явц	
Олон нийтийн саналыг авч тусгасан талаархи гүйцэтгэх засаглалын мэдээлэл (Асуулт 118)	Байхгүй
Төсвийн нээлттэй сонголын талаархи хууль тогтоох байгууллагаас гаргасан тайлан (Асуулт 122)	Байхгүй
Олон нийтийн саналыг авч тусгасан талаархи Аудитын дээд байгууллагын мэдээлэл (Асуулт 115)	Байхгүй

Судалгаа, аргачлал, найдвартай байдлын тодорхойлолт хийгээд судлаачидтай харилцах мэдээлэл

Нээлттэй төсвийн судалгаа нь практикт болсон явдлыг үнэлэхийн тулд амархан ажиглаж болох үзэгдлийг ашигладаг, баримтад тулгуурласан судалгааны хэрэгсэл юм. Судалгааны дүгнэлтийг ихэнх тохиолдолд эх сурвалж, саналаар баталгаажуулсан ба үүнд тодорхой төсвийн баримт бичиг, хууль, бусад нийтэд ил баримт бичгийн ишлэл, төрийн албан хаагчийн олон нийтэд хийсэн мэдэгдэл, мөн төрийн албан хаагч буюу бусад мэдээлэл бүхий этгээдтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлд үндэслэсэн болно. Засгийн газарт хамаарахгүй, хараат бус төсвийн шинжээчдийн улс орон бүрээр бөглөсөн асуулгыг нэгтгэж судалгааг гаргасан. Дараагаар нь улс орон бүрийн асуулгыг мөн тухайн улсын Засгийн газартай холбоогүй нэрийг нь дурьдаагүй хөндлөнгийн хоёр шинжээчээр дахин хянуулсан болно. Түүнчлэн Олон Улсын Төсвийн Түншлэл судалгааны урьдчилсан дүнгийн талаар саналаа өгөхийг Засгийн газруудаас хүсч, судалгааны үр дүнг эцсийн байдлаар гаргахаас өмнө дээрх саналуудыг авч үзсэн. 2012 оны судалгааны үйл явц 2011 оны 7 сараас 2012 оны 12 сар хүртэл нийт 18 сарыг хамарч, ойролцоогоор 400 шинжээчдийг татан оролцуулаа.

Нээлттэй төсвийн судалгаа нь Засгийн газрууд, хөгжлийн чиглэлээр ажиллагсад, хэвлэл мэдээлэл болон иргэдийг улсын

Зөвлөмж

Монгол Улсын хувьд дүн нь тааруу байгаа Нээлттэй төсвийн судалгааны үзүүлэлтийг авч үзсэний үндсэн дээр төсвийн үйл явц дахь олон нийтийн оролцоог өргөжүүлэхийг Олон Улсын Төсвийн Түншлэлээс зөвлөж байна. (Доорхи хүснэгт хийгээд Нээлттэй төсвийн судалгааны асуулгын Асуулт 114-125-ыг үзнэ үү).

төсвийн ил тод байдлын талаархи мэдээллийн найдвартай эх сурвалжаар хангадаг. Одоогоор судалгааны үр дүнг ашиглаж байгаа хэрэглэгчдийн тоонд Нээлттэй Засгийн Түншлэл, Африкийн төсвийн шинэчлэлийн хамтарсан санаачлага, Олон Улсын Аудитын Дээд Байгууллага, Дэлхийн Банк (Дэлхийн Засаглалын Үзүүлэлтийг гаргахдаа), мөн хэд хэдэн хоёр талт тусламжийн байгууллага, олон улсын хийгээд бүс нутгийн олон талт байгууллагууд багтдаг. Уг судалгаа нь төсвийн ил тод байдал, оролцоо, хариуцлагын талаархи даян дэлхийг хамарсан өгөгдлийн тэргүүний сан болохыг ийнхүү нийтлэгдэж буй Нээлттэй төсвийн судалгаа-2012 нотолж байна.

Монгол Улсын Нээлттэй төсвийн судалгааны ажлыг Н.Дорждарь гүйцэтгэсэн болно. Түүний хаяг: Нээлттэй Нийгэм Форум, Жамьян гүний гудамж-5/1, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-48, Dorjdari@forum.mn.

ОУТТ-ийн зүгээс олон удаа оролдсон ч Монгол Улсын Засгийн газраас Нээлттэй төсвийн асуулгын урьдчилсан дүнгийн талаар саналыг нь авч чадаагүй болно.